

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ  
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС  
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
<b>Үүрэг даалгавар НЭГ:</b> Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг бүх шатанд эрчимжүүлж, зураг төсөв, ажлын даалгаваргүй ажлуудыг шуурхай шийдвэрлэж, холбогдох байгууллагуудад хүргүүлж, захиалагчийн хяналтыг сайтар тавьж ажиллах.				
1	<p>Дүүрэгт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 он дамжин хэрэгжиж байгаа 146,923.1 сая төгрөгийн нийт 43 төсөл, арга хэмжээ байна.</p> <p>Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжих:</p> <ul style="list-style-type: none"><li>➤ 1 төсөл арга хэмжээ 300.0 сая төгрөг;</li><li>➤ 2022-2023 он дамжин хэрэгжих 10 төсөл арга хэмжээ 39,632.98 сая төгрөг;</li><li>➤ нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1 төсөл арга хэмжээ 1,200.0 сая төгрөг;</li><li>➤ 2022-2023 он дамжих хэрэгжих 4 төсөл арга хэмжээ 865 сая төгрөгийн төсөл арга хэмжээ хэрэгжиж байна.</li></ul> <p>Улс, Нийслэл, Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын нийт 59 төсөл арга хэмжээ хэрэгжих;</p> <ul style="list-style-type: none"><li>➤ Бэлтгэл ажил шатанд 8 төсөл арга хэмжээ;</li><li>➤ Тендерийн шатанд 11 төсөл арга хэмжээ;</li><li>➤ Гэрээ байгуулах шатанд 1 арга хэмжээ;</li><li>➤ Гэрээ байгуулагдан ажил хийгдэж буй 19 төсөл арга хэмжээ;</li><li>➤ Гүйцэтгэл 100% дууссан 20 төсөл арга хэмжээ тус тус хэрэгжиж байна.</li></ul> <p>- Нийслэлийн Замын хөгжлийн газар, Хөрөнгө оруулалтын газар, Барилгын хөгжлийн төвд дүүргийн нутаг дэвсгэрт Улс, Нийслэл, Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт тавин ажиллаж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг ирүүлэн хамтран ажиллах тухай албан бичгийг 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр хүргүүлэн ажилласан. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих нийт 24 төсөл арга хэмжээнээс 16 төсөл арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлэн ажиллаж байна.</p>			70

	<p>Төсвийн ерөнхийлөн захирагчийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр он дамжсан болон 2023 онд хэрэгжих 10 төсөл арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар ирээгүй, 2023 онд үнэлгээний хороо байгуулагдсан 48 төсөл арга хэмжээний тендер зарлагдсан төлөвтэй байна. Худалдан авах ажиллагааг цаг хугацаанд нь урилга үр дүнг нийтлэн түргэн шуурхай ажиллаж байна.</p>			
<p><b>Үүрэг даалгавар ХОЁР:</b> Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрт байгаа хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн, спортын талбайн өнгө, үзэмжийг сэргээх, засварлах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллах.</p>				
2	<p>Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК 1-6 дугаар хороодын Бичил цэцэрлэг тоглоомын талбайн аюулгүй байдал хангах ажлууд хийгдэж дууссан. Дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдэх 12, 14, 17, 18, 19 дүгээр хороодын бичил цэцэрлэгийн засварын ажлуудыг газар дээр очиж зураг төсвийг зөвшилцөн эхлүүлсэн. Дүүргийн хэмжээнд ашиглагдаж буй 9 усан оргилуурыг бүртгэн, засварлах шаардлагатай 2 байршлуудыг засварлуулах саналыг Нийслэлийн Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн. Дүүргийн 1-24 дүгээр хороод тус бүр нийт 39 хүүхдийн тоглоомын талбайн цэвэрлэгээ, засвар үйлчилгээг иргэдийн бүлэгтэйгээ хамтран Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс “Халамжийн тухай хууль”-ийн Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний Нийтийг хамарсан ажил хөтөлбөрт хамруулан зохион байгуулан ажиллалаа.</p>		70	
<p><b>Үүрэг даалгавар ГУРАВ:</b> Нийслэлийн хэмжээнд соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, соён гэгээрүүлэх, соёлын үнэт зүйлсийг өвлүүлэн эзэмшүүлэх, түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг хамгаалах болон нийгмийн салбарын ажлуудаа эрчимжүүлж, Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний төвтэй ажлаа уялдуулан хамтран ажиллах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийгмийн салбарын бүх шатны байгууллагууд, Дүүргийн Засаг дарга нар/</p>				
3	<p>Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, соён гэгээрүүлэх, соёлын үнэт зүйлсийг өвлүүлэн эзэмшүүлэх, түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг хамгаалах зорилгоор БСШУ-ны сайдын 2020 оны А-161 дүгээр тогтоол, 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Жагсаалт батлах тухай” Монгол улсын Засгийн газрын 13 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2008 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 357 дугаар захирамжийн дагуу нийт 28 түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрын мэдээллийг ТСҮХД-ыг бүртгэх Rich программд оруулж Соёлын өвийн үндэсний төвийн бүртгэл мэдээллийн санд нэмсэн. Шинээр дүүргийн хамгаалалтад нэмэгдсэн түүх соёлын дурсгалт 9 газрын гэрээг шинэчлэн боловсруулж байна.</p> <p>“Соёлын тухай хууль”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдөр “Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 46 дугаар зарлиг, Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөр, “Соёлтой иргэн-2024” арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Бахархалт монгол бичиг” тэмцээнийг дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын дунд амжилттай зохион байгуулсан.</p> <p>Хүн амын удмын сангийн аюулгүй байдал, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх Угийн бичиг хөтлөх ач холбогдол, аргачлалыг сурталчлан таниулах зорилгоор дүүргийн 1-6 дугаар хорооны иргэд, албан хаагчдад “Угийн бичиг хөтлөх арга зүйн сургалт”-ыг зохион байгуулж ажилласан.</p>		70	
<p><b>Үүрэг даалгавар ДӨРӨВ:</b> Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн аж ахуйн нэгжүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, жуулчны үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх</p>				

зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. /Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Байгаль орчны газар, Соёл урлагийн газар, Дүүргийн Засаг дарга нар/			
4	<p>Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, норм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/242 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн “Ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон үйл ажиллагааны удирдамж батлах тухай” А/120 дугаар захирамжаар “Иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлэхэд хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах тухай” удирдамж батлагдсан.</p> <p>Удирдамжийн хэрэгжилтийг ханган 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч 3 аж ахуйн нэгжүүдэд холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.</p>		70
<b>Үүрэг даалгавар ТАВ:</b> Гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, бэлгийн хүчирхийлэл, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлийн ажлуудаа эрчимжүүлж, шалтгаан нөхцөлд нь дүн шинжилгээ хийж нийслэлийн Удирдлагуудад танилцуулах. /Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар, Дүүргийн Засаг дарга нар/			
5	<p>Чингэлтэй дүүргийн хэмжээнд “Хүүхдийн тусламжийн утас 108”-д 1 дүгээр улирлын байдлаар нийт 166 дуудлага бүртгэгдсэнээс хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн 89 дуудлагад хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэн ажиллаад байна.</p> <p>Дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсээс төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагуудтай хамтран хүчирхийлэлд өртсөн 50 хүүхэд, иргэнд сэтгэлзүйн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.</p> <p>Насанд хүрээгүй гэр бүлийн хүчирхийллийн гэрч, хохирогч, холбогдогч 20 хүүхдэд хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.</p> <p>Хурдан морины унаач хүүхдийн эрхийг хамгаалах хүрээнд Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоолд жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглосон байдаг бөгөөд энэ хугацаанд дүүргийн нутаг дэвсгэрт хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахгүй байхад чиглэсэн арга хэмжээ авах, тогтоолын хэрэгжилтийг хангуулахад олон нийтийн оролцоо хяналтыг бий болгож, иргэдэд энэ талаар уриалга, мэдэгдэл гаргаж түгээх, тогтоолыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн талаарх мэдээллийг тухай бүр цагдаагийн байгууллагад мэдээлэх, шалгуулах арга хэмжээ авах талаар чиглэл өгч, хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран “Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг Олон улсын өдөр”-ийг тохиолдуулан хүүхдийг гэр бүлийн хүчирхийлэл болон сургуулийн орчинд гэмт хэрэг зөрчилд өртөх, холбогдохоос урьдчилан сэргийлэх, эцэг эх, багш нарт хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэхийн ач холбогдлыг таниулах нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахаар 10 төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна.</p>		70
<b>Үүрэг даалгавар ЗУРГАА:</b> Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлыг хангасан худалдаа, үйлчилгээний байгууллагуудын судалгааг гаргаж, хүртээмжийг сайжруулах зөвлөмж боловсруулан хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Дүүргийн Засаг дарга нар/			

6	<p>Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний газруудыг аттестатчилах тухай” удирдамжийг удирдлага болгон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээний хүртээмжтэй байдлыг хангуулах тухай зөвлөмж боловсруулан дүүргийн нутаг дэвсгэрт хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлыг хангасан худалдаа, үйлчилгээний 40 байгууллагын судалгааг гарган 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэст хүргүүлэн ажилласан.</p>			50
<p><b>Үүрэг даалгавар ДОЛОО:</b> " Нийслэлийн Татварын газраас орлого бүрдүүлэх ажлын хүрээнд дүүргүүдийн Татварын хэлтсүүдийг нэгдсэн удирдлагаар хангаж, орлого бүрдүүлэх тусгай удирдамж гарган нийслэлийн хэмжээнд орлого бүрдүүлэх ажлаа эрчимжүүлэх. /Нийслэлийн Татварын газар, Дүүргийн Засаг дарга нар/</p>				
7	<p>Чингэлтэй дүүргийн орлого бүрдүүлэлт 2023 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Улсын төсөвт 13,114.0 мянган төгрөг төлөвлөгдсөнөөс 19,659.0 мянган төгрөг төвлөрч 150%-н биелэлттэй;</li> <li>➢ Нийслэлийн төсөвт 2,735.15 мянган төгрөг төлөвлөгдсөнөөс 2,452.3 мянган төгрөг төвлөрүүлж 90%-н биелэлттэй;</li> <li>➢ Дүүргийн төсөвт 43,199.2 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 43,892.9 сая төгрөг төвлөрч 101,6%-ийн биелэлттэй байна.</li> </ul> <p>Дүүргийн төсвөөс Нийслэлийн төсөвт 28,935.1 сая төгрөг шилжүүлэхээс 28,935.1 мянган төгрөг шилжүүлж 100%-н биелэлттэй ажиллаж байна.</p> <p>Татварын төрөл бүрээр өрийн судалгаа гарган өмнөх оны болон тайлант оны өртэй татвар төлөгчдийн и-мейл хаяг болон утасны дугаарт мэдэгдэл хүргүүлэх, гэрийн хаягийг тодруулж шуудангаар нэхэмжлэл хүргүүлэх, өр барагдуулах нэхэмжлэхийн хугацаанд төлөлт хийгээгүй татвар төлөгчийн арилжааны банкин дахь харилцах дансны гүйлгээг хаах зэрэг арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.</p>		<p>1.Үл хөдлөх эд хөрөнгийн өөрчлөлтийн мэдээг тухай бүр татварын албанд ирүүлэх</p> <p>2.Төлөвлөгөө тасарч буй төрлүүд дээр тусгайлсан ажил зохион байгуулах</p> <p>3.Татварын бүртгэл цэгцлэх</p> <p>4.Өр барагдуулах нийтлэг ажиллагааг хэрэгжүүлэх</p> <p>5.Татвар төлөгчдийн өдрийг зохион байгуулах</p>	90

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН

ДАРГА

Л.БАЯРМАА

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

ДАРГА

Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.ЭНХГЭРЭЛ

НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН

МЭРГЭЖИЛТЭН

Т.ТҮВШИНЖАРГАЛ